

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ төрлийн Коронавирусын халдвар (Ковид-19)-аас сэргийлэхэд зориулж Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, гадаад улсаас эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт зэрэг төрийн байгууллагуудад сайн дурын үндсэн дээр бэлэн мөнгө, эд материал хандивлах, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх зэрэг хэлбэрээр дэмжин ажиллаж байгаа талаарх мэдээлэл төрийн байгууллагын цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өдөр тутам цацагдаж байна.

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийн эрсдлийг тооцож, гарч болзошгүй авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс холбогдох албан тушаалтан, байгууллагуудад зөвлөмж, зааврыг хүргүүлсээр байна. Тухайлбал, 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/2634 дугаартай албан бичгээр Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яаманд тус тус ЗӨВЛӨМЖ хүргүүлж, мөн оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01/12939 дүгээр албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөсөн болно.

Монгол Улсын Засгийн газраас “Ковид-19” халдвартай холбоотой хүндрэлийг даван туулах, эрсдэлтэй нөхцөл байдлаас гарах үр дагаврыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, монгол хүний хуулиар баталгаажуулсан эрхийг хангах зорилгоор тусгайлан хөрөнгө зарцуулах, халдвараас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж, сэрэмжлүүлгийг хүргэх, тусгай үүргийн нислэгээр иргэдээ эх оронд нь татан авчрах, хөл хорио тогтоох, хөдөлгөөнийг хязгаарлах, тусгаарлах байр бэлтгэх, тэдгээрийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж худалдан авах, онцгой нөхцөлд ажиллаж буй төрийн албан хаагчдыг хамгаалах хэрэгслээр хангах, илүү цагийн хөлс, урамшууллын асуудлыг шийдвэрлэх зэрэг олон арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж, банк, санхүүгийн болон олон улсын байгууллага, гадаад улстай хамтран хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ мөнгөний бодлогын хүүг бууруулах, зээлийн ангиллын журамд өөрчлөлт оруулах, нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэх, хүн амын орлогын албан татварыг авахгүй байх, гаалийн албан татвараас чөлөөлөх, шууд худалдан авалт хийхийг зөвшөөрөх зэргээр сүүлийн үед олон шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхээр болсон бөгөөд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, олон улсын байгууллагуудаас зээл, тусламж үзүүлэхээр яригдаж байна.

Дэлхий дахинд үүсээд байгаа цар тахлын нөхцөл байдлыг бага эрсдэлтэй даван туулах нь бидний гол зорилго. Онц байдлын үед тэгш бус байдал үүсч, шударга ёсны зарчим алдагдах, үнийн хөөрөгдөл бий болох, улсын төсөв, хандив тусламжийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах, завших, гүйцэтгэлд тавих хяналт сулрах зэрэг эрсдлүүд үүсч, авлигын гэмт хэрэг гардаг болохыг олон улсын байгууллагууд анхааруулан зөвлөж байна.

Жишээ: Эрүүл мэндийн сайд асанд авлигын хэргийн улмаас 5 жилийн хоригдох ял оноожээ. Кампала, Уганда (23.03.2020). Ардчилсан Конго Улсын Эрүүл мэндийн сайд асанд даваа гаригт 5 жилийн хорих ял оноожээ. Оли Илунга Каленга Оли Илунга¹-г өнгөрсөн 9 дүгээр сард баривчилсан ба Эбола вирустэй тэмцэхэд АНУ-аас олгосон 4.3 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг зүй бусаар зарцуулсан асуудалд буруутгасан байна. Тэрээр 2016 оноос өнгөрсөн оны 7 дугаар сар хүртэл Эрүүл мэндийн сайдын үүргийг гүйцэтгэж байсан. Шүүхээс түүнийг төрийн албанд ажиллах эрхийг хязгаарласан ба тэнсэн харгалзах болон ялын хугацаанаас бууруулахыг хориглох шийдвэр гаргажээ. Ардчилсан Конго Улсад хэд хэдэн удаа Эболагийн вирус дэгдэж байсан.

Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/africa/dr-congo-ex-health-minister-jailed-over-corruption/1776603>

Өмнө нь зохион байгуулж байсан өндөр хэмжээний уулзалт, зөвлөгөөний үеэр улсын төсөв, нийслэлийн төсөв, төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө, зээл, хандив, тусламжийн хөрөнгийг үр дүнгүй, хяналтгүй зарцуулсан, үл хамаарах арга хэмжээг

¹ Oly Ilunga Kalenga Oly Ilunga

санхүүжүүлсэн, худалдан авах ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн, уг үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн төсөв баталж мөрдөөгүй, уулзалт, хурлын ач холбогдол, үр дүнг дүгнэсэн баримтгүй байсан талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч байсныг цар тахалтай тэмцэж буй энэ үйл ажиллагааны явцад дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Жишээ: Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт, “АСЕМ”-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүн. Улаанбаатар хот (2018 оны 3 дугаар сар). Аудитын дүгнэлтээс:

- ✓ ... ҮАБЗ-ийн 2014 оны 63/37 дугаар зөвлөмжийн 3.5.7 дахь хэсгээр өгсөн зөвлөмжийг үндэслэл болгон ЗГ болон бусад төрийн байгууллагаас эрх зүйн шийдвэр гаргаж хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу “АСЕМ”-ын үйл ажиллагааг зохион байгуулахад хамааралтай гэж үзсэн бүх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгохдоо *шууд* гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчих нөхцөл бүрдүүлсэн байна...
- ✓ ...“АСЕМ”-ын үйл ажиллагаанд улс, нийслэлийн төсвөөс төсөвлөн зарцуулсан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтад тавих санхүүгийн хяналтыг холбогдох эрхийн актад орхигдуулснаас “АСЕМ”-ын үйл ажиллагаанд зарцуулсан 395.7 тэрбум төгрөгийн хөрөнгө хяналтгүй зарцуулагдсан байна...
- ✓ “АСЕМ” нэрийн дор түүнд хамааралгүй төсөл, арга хэмжээг хууль зөрчин шууд гэрээгээр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтгүй явуулсан байна...
- ✓ ...“АСЕМ”-ын үйл ажиллагаанд зориулж ирсэн хандив тусламжийг хүлээн авах, хуваарилахад ажлын хэсгийг ажиллуулаагүйгээс хандив, тусламжийн хөрөнгийн бүртгэл будлиантаж, бүрэн хэмжээгээр бүртгэлд тусгасан эсэх нь нотлогдохгүй байна...
- ✓ Аудитаар нийт 290,890.8 сая төгрөгийн зарцуулалттай холбоотой асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Эх сурвалж: <https://www.audit.mn/detail/5c4db1f663969dde04d31670>

Дээрх дурдсан нөхцөл байдлуудад дүгнэлт хийн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг хуулиар хүлээсэн бүрэн эрхийнхээ хүрээнд Авлигатай тэмцэх газраас дараахь ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Зөвлөмж 1. Иргэн, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, гадаад улсаас үзүүлж буй хандивын хөрөнгө, үйл ажиллагааны зарлага нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т заасанчлан төсвийн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хөрөнгийг **бүртгэх, зарцуулах, тайлагнах арга хэмжээг** зохион байгуулж, олон нийтэд нэг эх сурвалжаас мэдээлэл авах боломжийг олгох, үнэн зөв мэдээллээр хангах;

Нөхцөл байдал: Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар цугларсан нийт 717 110 068 (бэлнээр 203 459 270, бэлэн бусаар 517 150 798) төгрөг, 231 иргэн, аж ахуйн нэгж 371 644 ширхэг эд материалын хандив, тусламжийг үзүүлсэн тухай, Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар цугларсан хандив (нийт мөнгөн дүнг харах боломжгүй)-ын талаарх мэдээллийг тус тус байршуулсан. Мөн Онцгой байдлын ерөнхий газар нь албан ёсны хандивын данс (төрийн сангийн 100900031405 тоот данс)-ны дугаарыг цахим хуудсандаа байршуулсан боловч хандивын хөрөнгийн зарцуулалтын талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

Зөвлөмж 2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандивтай холбоотой хязгааралтыг зөрчихөөс урьдчилан сэргийлж, нийтийн албан тушаалтан, ялангуяа төрийн жинхэнэ албан хаагчийг аливаа эрсдэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагын улмаас хандив, тусламжийн хөрөнгийг **зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан авах** зохицуулалтыг баримтлах;

Эрх зүйн зохицуулалт:

- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа

нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

- ✓ Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4.Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараахь тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно:..
- ✓ Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.1-ийн 6-д зааснаар Сангийн яам нь “Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх” арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан.

Нөхцөл байдал:

- ✓ Өнөөдрийн тохиолдолд төрийн тусгай болон төрийн захиргааны албан тушаалтан нь шууд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улсын тусламжийг хүлээн авч байгаа тухай баримт, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, социал орчинд түгээмэл гарч байна.

Зөвлөмж 3. Онц байдлын үед үүрэг гүйцэтгэж байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтан, мэргэжлийн хяналт, онцгой байдал, цагдаагийн байгууллагын болон бусад ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл боломжоор хангах, тэдэнд нэмэлт ачаалал үүрүүлэхгүй байх, шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл ... зэргийг худалдан авах үйл ажиллагааг аль болох мэргэжлийн байгууллага (*Сангийн яамны холбогдох нэгж, Төрийн худалдан авах ажиллагааны газар, нутгийн захиргааны байгууллагын худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан нэгж*)-аар шуурхай гүйцэтгүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

Зөвлөмж 4. Онц байдлын үед Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлогын шинжтэй арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тусгайлан анхаарах, иргэд, олон нийтийн дунд хүлээлт үүсгэсэн асуудлуудад тухай бүр шийдэл, гарцыг тодорхойлж, шуурхай шийдвэрлэх, олон нийтэд мэдээллийг нээлттэй, дэвшилтэт техник технологийг ашиглаж тогтмол хүргэх, хүнд суртал, чирэгдэл үүсгэхгүй байх;

Зөвлөмж 5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй нөхцөлд шууд гэрээ байгуулсан этгээд буюу гүйцэтгэгч нь улс төрд нөлөө бүхий этгээд болон түүний хамаарал бүхий этгээд биш байхад онцгойлон анхаарах, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх;

Эрх зүйн зохицуулалт:

- ✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5.“улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;
- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа

гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.

- ✓ Эрүүгийн хуульд тайлбарласнаар “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Баримт ...



Эрүүл мэндийн яаманд хандивласан эд, материалын тайлан /2020.02.01-2020.03.27-ний байдлаар/

№	Огноо	Материалын үнэг, зүйлийн нэр, зэрэг, дугаар	Харилцагч	Хэмжээ нэгж	Тус дэмжлэг
1	2020.02.01	Нэг удагийн амны хаалт	О.Баттосол УИХГ	Шерхэг	5,000
2	2020.02.01	Нэг удагийн амны хаалт	"Монхийн тун" ХХК	Шерхэг	1,000
3	2020.02.01	Ирээ амны хаалт	"МЦЖ" ХХК	Шерхэг	500
4	2020.02.01	Хажуу хөмсөг	"Мэдэр Эвдэн" ХХК	Шерхэг	10
5	2020.02.01	Ариутгалын спирт, дөнгөрөг	Монгол эмийн үйлдвэр	Литр	1,000
6	2020.02.01	Нэг удагийн амны хаалт /хуудайтай/	Б.Срөгэнд	Шерхэг	200
7	2020.02.01	Нэг удагийн амны хаалт	Наран эмийс	Шерхэг	2,000
8	2020.02.01	Хамт явсан хуучин	"Энхэн" ХХК	Шерхэг	100
9	2020.02.03	Нэг удагийн амны хаалт	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн	Шерхэг	25,000
10	2020.02.03	Хамт явсан хуучин	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн	Шерхэг	100
10	2020.02.07	Дажуур мах	Нийслэлийн Захирагчийн Гэрээний Хэлтэс	Шерхэг	3,500
11	2016.02.10	Дажуур амны хаалт мах, цамц	М.Эрдэмбат		
12	2016.02.10	Дажуур амны хаалт	М.Эрдэмбат		



Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хандивын нэгдсэн мэдээллийг энд дарж үзнэ үү?



Хөгжцөвтэй холбоотой мэдээллийг доош линкүүдээг заах боломтой.

ХАНДИВЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

gogo.mn
7 mins
Туушин ХХК ЭМЯ-нд гучин сая төгрөгийн мөнгөн хандив өргөж, мөн эмнэлэг, эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хамгийн хямд өртөгөөр тээвэрлэхээ илэрхийлэв.



GOGO.MN
"Туушин" ХХК-ийн хамт олон ЭМЯ-нд 30 сая төгрөг хандивлав

Дэд	Огноо	АМНДАНГУУЛСАН НЭР	Мөнгөн хэмжээ	ДЭ	Огноо	АМНДАНГУУЛСАН НЭР	Мөнгөн хэмжээ	Утга
1	2020.02.01	О.Баттосол УИХГ	5,000,000.00	А	2020.02.01	О.Баттосол УИХГ	5,000,000.00	О.Баттосол УИХГ
2	2020.02.01	"Монхийн тун" ХХК	1,000,000.00	А	2020.02.01	"Монхийн тун" ХХК	1,000,000.00	"Монхийн тун" ХХК
3	2020.02.01	"МЦЖ" ХХК	500,000.00	А	2020.02.01	"МЦЖ" ХХК	500,000.00	"МЦЖ" ХХК
4	2020.02.01	"Мэдэр Эвдэн" ХХК	10,000,000.00	А	2020.02.01	"Мэдэр Эвдэн" ХХК	10,000,000.00	"Мэдэр Эвдэн" ХХК
5	2020.02.01	Монгол эмийн үйлдвэр	1,000,000.00	А	2020.02.01	Монгол эмийн үйлдвэр	1,000,000.00	Монгол эмийн үйлдвэр
6	2020.02.01	Б.Срөгэнд	200,000.00	А	2020.02.01	Б.Срөгэнд	200,000.00	Б.Срөгэнд
7	2020.02.01	Наран эмийс	2,000,000.00	А	2020.02.01	Наран эмийс	2,000,000.00	Наран эмийс
8	2020.02.01	"Энхэн" ХХК	100,000.00	А	2020.02.01	"Энхэн" ХХК	100,000.00	"Энхэн" ХХК
9	2020.02.03	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн	25,000,000.00	А	2020.02.03	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн	25,000,000.00	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн
10	2020.02.03	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн	100,000.00	А	2020.02.03	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн	100,000.00	Нийслэлийн Зүүн Мэргэжлийн
10	2020.02.07	Нийслэлийн Захирагчийн Гэрээний Хэлтэс	3,500,000.00	А	2020.02.07	Нийслэлийн Захирагчийн Гэрээний Хэлтэс	3,500,000.00	Нийслэлийн Захирагчийн Гэрээний Хэлтэс
11	2016.02.10	М.Эрдэмбат			2016.02.10	М.Эрдэмбат		М.Эрдэмбат
12	2016.02.10	М.Эрдэмбат			2016.02.10	М.Эрдэмбат		М.Эрдэмбат

KFC
March 11 at 11:39 AM
KFC бренд МХЕГ азарт 10,000,000 төгрөгийн үнэ бүхий "Вирусээс хамгаалах иж бүрэн хэрэгсэл" хандивлалаа.
Бид шинэ коронавирусын (Covid-19) эрчимтэй тархалттай холбоотойгоор Монгол улсынхаа хүн ардын эрүүл мэндийн төлөө зогсолтгүй ажиллаж байгаа Мэргэжлийн Хяналтын Газрын хамт олондоо дэмжлэг үзүүлэв.
Мөн шинэ коронавирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх зорилгоор улс даяар анхааран ажиллаж байгаа энэ үед салбар бүрдээ ариун цэврийг өндөр сахин тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт хийн, ажилтан бүр амны хаалт зүүн ажиллаж байна.
Энэхүү гамшигт аюлаас сэргийлэхэд хүн бүхний хүчин чармайлт хэрэгтэй тул албан ёсны эх сурвалж бүхий мэдээлэлд итгэж, тайван ухаалгаар хандан, хамтдаа хүнээгээ хэмээн KFC брэндийн зүгээс ард иргэддээ уриалж байна.



Нийслэлийн онцгой, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагад тус бүр 5 сая төгрөг хандивлалаа



АНУ Монгол Улсад 3.3 тэрбум төгрөгийн тусламж үзүүлнэ



Эрүүл мэндийн яамнаас ээлжит мэдээллээ хийж байна.

АНУ-ын Засгийн газар COVID-19 вирусийн тархалтаас сэргийлэхэд зориулан Монгол Улсад 3.3 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж байгааг мэдээллийн эхэнд лvvлгав. АНУ-ын Элчин сайл Майкл С. Кле...